

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНД ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

2022 оны 04 дүгээр
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12 дахь заалт болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.1 дэх хэсэг, 112.2.13 дахь заалтыг үндэслэн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл /цаашид “ЭМДҮЗ” гэх/ 2021 оны үйл ажиллагааны тайлангаа 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 23 дугаар албан бичгээр Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороонд ирүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.3 дахь хэсэг, Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны “Системчилсэн үнэлгээ хийх тухай” 05 дугаар тогтоолын дагуу ЭМДҮЗ-өөс ирүүлсэн “2021 оны үйл ажиллагааны тайланд хийсэн системчилсэн үнэлгээний тайлан” болон “2021 оны үйл ажиллагааны тайлан”-гийн хүрээнд Улсын Их Хурлын Тамгын газраас шинжилгээ хийхдээ дараах асуудлыг хамруулан гүйцэтгэлээ.

1. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь хуулиар олгосон чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар;
2. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар Улсын Их Хурал, Засгийн газраас үүрэг, чиглэл болгосон тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн талаар;
3. Байгууллагын үйл ажиллагаандаа системчилсэн үнэлгээ хийсэн эсэх талаар зэрэг болно.

НЭГ.ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ НЬ ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГЭЭ ХЭРХЭН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН ТАЛААР:

ЭМДҮЗ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан эрх, үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтэц, дүрмийг батлах, эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангийн хөрөнгийг тооцох, төрийн санд байршуулах, зарцуулах журмыг батлах, эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг төрийн санд байршуулах, зарцуулах журмыг батлах, эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж, эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар холбогдох байгууллагаас ирүүлсэн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, санал боловсруулах, эрх бүхий этгээдээр шийдвэрлүүлэх, даатгалын гэрээний дагуу худалдан авсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг олон улсын эмнэл зүйн удирдамж ашиглан батлах зэрэг эрхтэй.

Эрүүл мэндийн даатгалын сангийн болон эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардлын төсвийн төсөл, төсөөлөл, төсвийн хүрээний мэдэгдлийг актуар тооцоололд үндэслэн боловсруулах, батлагдсан төсвийн нарийвчилсан хуваарийг батлах, гүйцэтгэлд нь хяналт тавих, эрүүл мэндийн даатгалын сангийн болон эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны тайланг хэлэлцэх, үйл ажиллагааны болон удирдлагын зардлыг хянах, эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад орох тусламж, үйлчилгээний жагсаалтыг батлах, эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй

шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг тогтоох, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журмыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлах зэрэг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөндөө нийт 51 ажил, үйлчилгээг 80.7 хувийн биелэлттэй хэрэгжүүлэн ажилласан бөгөөд 100 хувийн хэрэгжилттэй 43 арга хэмжээ, 90 хувийн хэрэгжилттэй 6 арга хэмжээ, 80 хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ, 70 хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ байна гэж тайлагнасан.

ЭМДҮЗ нь 2021 оны үйл ажиллагааны тайлангаа ирүүлэхдээ эрүүл мэндийн даатгалын санг удирдах, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтцийг батлах, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, төсвийн гүйцэтгэл боловсруулах, хяналт тавих зэрэг хуулиар олгосон чиг үүргийн хэрэгжилтээс гадна эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ, эрүүл мэндийн даатгалын хамралт, хяналт, салбарын цахим системийн хөгжүүлэлт, сургалт сурталчилгаа, коронавируст халдварт цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийн талаар тайлагнасан байна.


1.1 Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, төсвийн гүйцэтгэл

Эрүүл мэндийн даатгалын сангийн болон эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардлын төсвийн төсөл, төсөөлөл, төсвийн хүрээний мэдэгдлийг актуар тооцоололд үндэслэн боловсруулах, батлагдсан төсвийн нарийвчилсан хуваарийг батлах, гүйцэтгэлд нь хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэн дараах үр дүнг гарган ажилласан байна. Үүнд:

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хуульд эрүүл мэндийн даатгалын санд 951.2 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр баталснаас ЭМДС-ийн орлогын гүйцэтгэл 1,002.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 105 хувиар өссөн байна.

Харин эрүүл мэндийн даатгалын сангийн нийт зарлага 1,210.7 тэрбум төгрөг байхаар баталснаас тус сангийн зарлагын гүйцэтгэл 1,208.1 тэрбум төгрөг буюу 99.8 хувьтай байгаа ба өмнөх оны гүйцэтгэлээс 13 хувиар нэмэгдсэн байна.

Зураг 1. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны орлого, зарлагын гүйцэтгэл (тэрбум төгрөгөөр)



ЭМД-ын шимтгэлийн хувь хэмжээг сүүлийн 5 жилд нэмэгдүүлээгүй, тогтвортой барих чиглэлийг үндэсний зөвлөл баримтлан ажилласан ба 2021 онд 3,251.4 мянган даатгуулагч эрүүл мэндийн даатгалд хамрагдаж, хамралтын түвшин 96.8 хувьтай байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 2021 онд тусламж, үйлчилгээний зардалд 1,159.2 тэрбум төгрөг олгохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр тооцон 100 хувь олгож, үйл ажиллагааны зардалд 7.5 тэрбум төгрөг, Нийгмийн даатгалын байгууллагад 1.1 тэрбум

төгрөг, илүү төлсөн шимтгэлийн буцаан олголтод 79.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан гэж тайлагнасан байна.

ЭМДҮЗ-ийн хэрэгжүүлсэн бодлого, гүйцэтгэсэн ажлын үр дүн нь эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого, эрүүл мэндийн даатгалд хамрагдалтаар илэрхийлэгддэг бөгөөд 2021 онд шимтгэлийн орлогыг 443.1 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс Эрүүл мэндийн даатгалын санд 491.5 тэрбум төгрөг бүрдүүлж, шимтгэлийн орлогын төлөвлөгөө 110 хувиар биелсэн байна. Харин 2021 онд 3,251.4 мянган даатгуулагч эрүүл мэндийн даатгалд хамрагдаж, хамралтын түвшин 96.8 хувьтай байна.

1.2 Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх:

ЭМДС-аас зардлын төлбөрийг хариуцах эрүүл мэндийн багц тусламж үйлчилгээ: ЭМДҮЗ-ийн шинэчлэн баталсан 2021 оны 03 дугаар тогтоолоор эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, өртгийн жинг шинэчлэн баталсан бөгөөд уг тогтоолд нийт 120.2 мянган давхардсан онош багтсан байна.

Эмийн үнийн хөнгөлөлтийн тусламж, үйлчилгээ: Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад орох тусламж, үйлчилгээний жагсаалтыг эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах чиг үүргийн хүрээнд эрүүл мэндийн даатгалын сангаас 2021 оны байдлаар 1731 эмийн сангаар дамжуулан 2.2 сая хүнд 104.2 сая ширхэг эмийг хөнгөлөлттэй олгож 60.4 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өмнөх оноос 24.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Хөнгөлөлттэй эмийн олголттой холбоотой өндөр үнэтэй эмийг их хэмжээгээр бичих, даатгалын санхүүжилт эрт дуусах, эмийн үнийн дээд хязгаарыг хэтрүүлэх зэрэг түгээмэл тулгардаг асуудал, түүнийг шийдвэрлэхэд чиглэсэн арга хэмжээний талаарх мэдээллийг тайланд тусгаагүй байна.

Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж, үйлчилгээ: Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг хариуцах 4 төрлийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлж 2021 онд 444.3 мянган тохиолдолд 15.1 тэрбум төгрөг зарцуулсан байна. Өмнөх онтой харьцуулахад 53 мянган хүнээр буурсан бол, олгосон санхүүжилт нь 3.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнээс оношилгоо, шинжилгээний тусламж үйлчилгээ нийт тохиолдлын 58.1 хувь, санхүүжилтийн 17.8 хувийг тус тус эзэлж байна. Харин гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ нийт тохиолдлын 13.7 хувь, нийт санхүүжилтийн 37.4 хувийг эзэлж, 5.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ: Гэрээ бүхий 202 эрүүл мэндийн байгууллагаар 18-аас дээш насны даатгуулагчдын 4.4 хувь буюу 96.8 мянган даатгуулагч нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлээс хамааруулан урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамрагджээ. Урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалт өмнөх онтой харьцуулахад буурсан нь коронавируст халдварын цар тахлын үеийн бүх нийтийн хөл хориотой холбоотойгоор иргэд эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэх явдал багассантай холбоотой байна.

Коронавируст халдварын үеийн тусламж, үйлчилгээ: Коронавируст халдварт цар тахлын дэгдэлтийн үед нийт давхардсан тоогоор 4852 эрүүл мэндийн байгууллагаар дамжуулан давхардсан тоогоор 7,749,969 иргэнд 368.6 тэрбум төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулсан байна. Мөн ЭМДС-аас 2021 оны байдлаар 1,731 эмийн сангаар дамжуулан 2.2 сая хүнд 104.2 сая ширхэг эмийг хөнгөлөлттэй олгож 60.4 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өмнөх оноос 24.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

1.3 Цахим систем

Эрүүл мэндийн даатгалын байгууллагын төлбөр, тооцоо, даатгуулагчид болон ажил үйлчилгээ худалдан авах байгууллагуудтай харилцах, даатгалын санд хяналт тавих ажиллагаа цахим хэлбэрт шилжиж, гэрээ бүхий 2577 төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, эмийн сан эрүүл мэндийн даатгалын цахим системд бүртгэгджээ. Түүнчлэн иргэд, даатгуулагчид “E-Mongolia” төрийн нэгдсэн системээс 2016 оноос хойших эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээллийг харах, төлөгдөөгүй шимтгэлийг нөхөж төлөх боломжийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, E-Mongolia, Хур системрүү эрүүл мэндийн даатгал шимтгэл төлөлт харуулах сервис хүлээлгэж өгсөн байна.

ХОЁР. ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ТАЛААР УЛСЫН ИХ ХУРАЛ, ЗАСГИЙН ГАЗРААС ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ БОЛГОСОН ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР:

2021 оны байдлаар ЭМД-ын байгууллага нь Монгол Улсын 4 хуулийн 38 заалт, Монгол Улсын Их Хурлын 4 тогтоолын 6 заалт, Засгийн газрын 17 тогтоолын 43 заалт, Засгийн газрын 16 хуралдааны тэмдэглэлийн 37 заалт, Засгийн газрын 4 албан даалгаврын 18 заалт, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 8 тогтоолын 16 заалт, Эрүүл мэндийн сайдын 10 тушаалын 29 заалт, ЭМДЕГ-ын даргын 40 тушаалын 59 заалт, нийт 103 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 246 заалтыг хяналтад авч, 97.8 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн байна.

2.1 Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа болон Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн талаар:

Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед төсвийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай” 168 дугаар тогтоол гарсаны дагуу ЭМДҮЗ нь ЭМДС-г удирдах, нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн хөрөнгийг төрийн сангийн нэгдсэн дансанд төвлөрүүлэх, эрсдэлийн сан байгуулах зэрэг арга хэмжээг авч ажиллажээ. 2021 оны жилийн эцсийн байдлаар Эрүүл мэндийн даатгалын сан Төрийн санд хадгаламж хэлбэрээр 100.0 тэрбум төгрөг, харилцах дансанд 162.1 тэрбум төгрөг, арилжааны 7 банкны харилцах дансанд 156.7 тэрбум төгрөг, нийт сангийн үлдэгдэл 418.8 тэрбум төгрөг байна.

ЭМД-ийн хамралт өмнөх оноос 5.9 хувиар нэмэгдэж, 96.8 хувьд хүрч, ЭМД-ын сангаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг давхардсан тоогоор 10.3 сая даатгуулагчид хүргэж, 1,159.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон нь өмнөх жилээс 2 дахин өсжээ.

Эрүүл мэндийн тухай хуульд орсон өөрчлөлттэй холбогдуулан амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээний багц, амбулаторийн жижиг мэс ажилбар, амбулаторийн хяналтын үзлэг, уламжлалтын үзлэг, өндөр өртөг бүхий оношилгоо, шинжилгээ, өдрийн мэс засал, уламжлалт эмчилгээ зэрэг үйлчилгээний төрлүүдийг нэмж ЭМД-аас санхүүжүүлэхээр болж, өмнө нь улсын төсвөөс санхүүжиж байсан төлбөрийг нь төр хариуцах жирэмсний хяналтын багц, диализын эмчилгээ, эрчимт эмчилгээ, яаралтай тусламж, түргэн тусламжийн төрлүүдийг багцад нэмж оруулж өгсөн нь хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээг хангах, даатгуулагчийг санхүүгийн эрсдэлээс хамгаалах, ЭМД-ын тусламж, үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлсэн үр дүнтэй ажил болсон байна.

Түүнчлэн тусламж, үйлчилгээний тусгай багц болон санхүүждэг байсан 650 нэр төрлийн “Өндөр өртөг бүхий мэс заслын тусламж, үйлчилгээний хэрэгсэл”-ийн зардлыг үндсэн мэс заслын өртөгт нь шингээсэн байна.

Мөн даатгуулагч хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад үйлчлүүлж, амбулаторийн болон өдрийн эмчилгээ, үйлчилгээ авах үед ЭМДС-аас санхүүжилт олгогддоггүй байсныг өөрчилж улсын болон хувийн хэвшлийн ЭМБ-уудыг ялгалгүйгээр ЭМД-ын тусламж, үйлчилгээний бүх төрлийн тусламж, үйлчилгээнд санхүүжилт олгохоор өөрчилсөн нь төрийн болон хувийн өмчийн ЭМБ-ын ялгааг арилган, хувийн хэвшлийн ЭМБ-аас ЭМД-ын бүх төрлийн тусламж, үйлчилгээг үзүүлэх боломжтой болж байгууллага хоорондын өрсөлдөөнийг дэмжиж, даатгуулагчид сонголт хийх боломжийг бий болгосон байна.

Даатгуулагчид ЭМД-ын гэрээтэй ЭМБ-аар үйлчлүүлэхэд хамтын төлбөр/даатгуулагчаас төлөх хувь/-өөс өөр нэмэлт төлбөр авахгүй байх нөхцөлийг бүрдүүлж, даатгуулагчийн тусламж, үйлчилгээ авахдаа төлөх хамтын төлбөрийн хэмжээг тухайн тусламж, үйлчилгээний нэн шаардлагатай байдал болон өртөг зардлын хэмжээнээс хамааруулан ялгаатай тогтоож өгсөн байна. Тухайлбал, улсын төсвөөс өмнө нь санхүүжүүлж байсан бүх тусламж, үйлчилгээнүүд болон амь, насыг аврах нэн шаардлагатай болон төрөлхийн гажигийн тусламж, үйлчилгээнүүд хамтын төлбөргүй, мэс заслын тусламж, үйлчилгээ 10-25 хувь, мэс заслаас бусад төрлийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ 10-15 хувь, өндөр өртөг бүхий оношилгоо, шинжилгээг 30 хувиар тогтоожээ. ЭМД-ын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.3-т заасан шимтгэлийг нь төр хариуцах иргэдийг хамтын төлбөрөөс чөлөөлөхөөр болсон нь тухайн иргэдийг санхүүгийн эрсдэлээс хамгаалах чухал алхам болсон гэж үзсэн байна.

Тус шинэчлэлийн хүрээнд 2021 онд эмнэлгийн тусламж, үйлчилгээний 5.4 сая тохиолдлын 550.3 тэрбум төгрөгийг ЭМДС-аас гэрээ бүхий төрийн болон хувийн хэвшлийн 331 ЭМБ-д олгосон байна. Тусламж, үйлчилгээний нийт тохиолдлын 69.5 хувь, санхүүжилтийн 76.0 хувийг ЭМД-ын шимтгэлийг нь төр хариуцах иргэд буюу 0-18 насны хүүхэд, тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн, хүүхдээ асарч буй эх/эцэг, ял эдэлж байгаа ялтан, хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч нар эзэлж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 176 дугаар тогтоолоор агентлагийн орон тооны дээд хязгаарыг 170 байхаар тогтоосны дагуу ЭМДҮЗ-ийн тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын бүтцийг шинэчлэн баталж, 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 21 аймаг, Багануур, Налайх дүүрэгт Эрүүл мэндийн даатгалын хэлтсийг байгуулж үйл ажиллагаагаа өргөжүүлсэн байна.

2.2. УИХ-ын Байнгын хорооноос өгсөн үүрэг, чиглэлийн биелэлтийн талаар:

Нийгмийн бодлогын байнгын хорооны 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар ЭМДҮЗ-ийн 2020 оны үйл ажиллагааны тайланг сонссон бөгөөд ЭМДҮЗ-д Байнгын хорооны тогтоолоор үүрэг, чиглэл өгөгдөөгүй байна.

Харин ЭМДҮЗ-өөс НББСШУБХ-ны 2019 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн ЭМДҮЗ-ийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 08 дугаар тогтоолоор өгсөн үүрэг, чиглэлийн биелэлт болон ЭМДҮЗ-ийн 2018 оны үйл ажиллагааны тайланг Байнгын хорооны хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх, санал дүгнэлт, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайланг хэлэлцээд Байнгын хорооны хуралдааны тэмдэглэлээр Засгийн газарт өгсөн 10 заалт бүхий үүрэг, чиглэлийн хэрэгжилтийг дахин тайлагнаж ирүүлсэн байна. Ингэхдээ 2021 онд нэмж хийгдсэн ажлын тоон мэдээллийг шинэчлэх байдлаар тайлагнаж ирүүлжээ.

Байнгын хорооны хуралдаанаар ЭМДҮЗ-ийн 2020 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэхэд хөндөгдсөн гол асуудал болох Капитал банк дахь эрүүл мэндийн даатгалын сангийн авлагыг шуурхай барагдуулах болон эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалтын асуудал байсан. Энэ хүрээнд ЭМДҮЗ нь даатгалын сангийн хөрөнгийг олж авах талаар чиглэл өгч, ЭМДЕГ хууль, эрх зүйн хүрээнд сангийн хохирлыг шуурхай барагдуулахаар ажлын хэсэг байгуулан ажиллаж байгаа талаар тайланд дурджээ.

“Капитал банк” ХХК дахь банкны эрх хүлээн авагчаас цаашид зөвхөн зээлийн төлөлтөөр, мөнгөн хэлбэрээр даатгалд учирсан хохирлыг барагдуулах нь хугацаа их

шаардах, бүрэн төлөгдөх эсэх нь эргэлзээтэй тул Капитал банкны хөрөнгөнд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгөөс нэхэмжлэлийн шаардлагад тооцож, өмчлөх эрхээр гаргаж, шилжүүлэн авах байдлаар төлбөр барагдуулахыг санал болгон хөрөнгийн жагсаалтыг гаргаж ЭМДЕГ-т ирүүлсэн байна.

Капитал банкнаас авах өрийг барагдуулахтай холбогдуулан ЭМДҮЗ-ийн 2021 оны “Өр төлбөр барагдуулах тухай” 06 дугаар тогтоолоор өр төлбөрт тооцон авах боломжтой 61.7 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий 74 үл хөдлөх хөрөнгийн жагсаалтыг баталж, биелэлтийг хангуулан, өр төлбөрт шилжүүлэн авч байгаа үл хөдлөх хөрөнгийг даатгалын сангийн авлагад хүлээн авах, хадгалах, хамгаалах, ашиглах, түрээслүүлэх, худалдан борлуулах журмыг батлан мөрдүүлжээ.

2021 оны жилийн эцсийн байдлаар Капитал банк ХХК-наас авах өр төлбөрөөс 8.1 тэрбум төгрөгийг мөнгөн хэлбэрээр, 06 дугаар тогтоолын дагуу 36.4 тэрбум төгрөгийн үнэ бүхий 39 объект, НДЕГ-тай хамтран 10 объектыг тус тус шилжүүлэн авч, 91.6 тэрбум төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

2.3. ЭМДҮЗ-ийн тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн талаар:

ЭМДҮЗ нь тайлант онд Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, түүнд шинээр орсон нэмэлт өөрчлөлтөд нийцүүлэн даатгалын харилцааг боловсронгуй болгох, сангийн удирдлага, менежментийг сайжруулахад чиглэсэн журам, зааврыг шинэчлэх, Улсын Их Хурлын Байнгын хорооноос баталсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, Коронавируст цар тахлын нөхцөл байдалд даатгалын сангийн үйл ажиллагааг сайжруулахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажилласан байна.

ЭМДҮЗ нь 2021 онд 4 удаагийн хуралдаанаар 16 асуудлыг хэлэлцэн баталж, шинээр 13 тогтоол шийдвэрийг батлан гаргасан байна. Тайлант хугацаанд “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 03 дугаар тогтоол, “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” /өрх, сум, тосгон/ 04 дүгээр тогтоолыг шинэчлэн баталж Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж ажиллажээ.

Харин эрүүл мэндийн даатгалын салбарын үйл ажиллагааг зохицуулж буй хэчнээн дүрэм, журам байгаа, үүнээс хэд нь хэм хэмжээ тогтоосон акт болох талаар, мөн нийт хэм хэмжээ тогтоосон актаас хэдийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн “захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэл”-д бүртгүүлсэн талаар тодорхой тайлагнаж ирүүлээгүй байна.

Хүснэгт 1. ЭМДҮЗ-ийн 2021 онд баталсан тогтоол

№	Огноо	Дугаар	Утга
1	2021.01.22	01	2021 оны төсвийн хуваарийг батлах тухай
2	2021.01.22	02	Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сан байгуулах тухай
3	2021.01.22	03	Төлбөрийн хэмжээ, арга, журам шинэчлэн батлах тухай
4	2021.04.20	04	Төлбөрийн хэмжээ, арга, журам шинэчлэн батлах тухай /өрх, сум, тосгон/
5	2021.04.20	05	Хяналтын журам батлах тухай
6	2021.04.20	06	Өр төлбөр барагдуулах тухай
7	2021.12.21	07	2021 оны төсвийн хуваарийг шинэчлэн батлах тухай
8	2021.12.21	08	2022 оны төсвийн хуваарийг батлах тухай
9	2021.12.21	09	Журам шинэчлэн батлах тухай
10	2021.12.21	10	Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сан байгуулах тухай
11	2021.12.21	11	ЭМДС-ын авлагад үл хөдлөх хөрөнгийг хүлээн авах, хадгалах, хамгаалах, ашиглах, түрээслүүлэх, худалдан борлуулах журам батлах тухай
12	2021.12.21	12	Үр дүнгийн урамшуулал олгох тухай
13	2021.12.21	13	Гэрээний үлгэрчилсэн загвар батлах тухай

Мөн 2021 оны жилийн эцсийн байдлаар ЭМДҮЗ-ийн 22 тогтоол хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаагаас:

- ЭМД-ын санг удирдан чиглүүлэх, нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр 8;
- ЭМД-ын үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийн талаар 4;
- Ажлын албаны дотоод үйл ажиллагаатай холбоотой 1 тогтоолын хэрэгжилтийг тус тус хангуулан ажилласан байна.

ЭМДҮЗ-ийн 2021 оны 05 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын журам”, журмын хэрэгжилтийг хангах зорилгоор ЭМБ-аас ирүүлсэн нэхэмжлэлийг хянах үйл ажиллагаа, төлбөр гүйцэтгэх үйл явц, нэхэмжлэлийн хяналтын тайлан, хяналтын үр дүнд дүн шинжилгээ хийх, хариу арга хэмжээ авах, ЭМБ-д мэдээлэх, эргэх холбоо тогтоох зорилго бүхий “Нэхэмжлэлийн хяналт хийх журам”-ыг тус тус боловсруулан баталжээ. Уг ажлын хүрээнд “Эрүүл мэндийн даатгалын цахим системд хөгжүүлэлт хийх, нэмэлт өөрчлөлт оруулах програмын бодлогын даалгавар”-ын цахим системийн хөгжүүлэлт 80 хувийн гүйцэтгэлтэй байгаа талаар үйл ажиллагааны тайланд дурджээ.

ЭМДС-аас төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр ЭМДҮЗ-ийн 2021 оны 03 дугаар тогтоолоор ЭМДС-аас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, өртгийн жинг шинэчлэн тогтоож, нийт 562 оношийн хамааралтай бүлэг бүхий 120.2 мянган давхардсан оношийг баталсан байна. Тус тогтоолоор тусламж, үйлчилгээний суурь тарифыг 21-113 хувиар нэмэгдүүлжээ. Тухайлбал, хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний суурь тарифыг 450.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 850.0 мянган төгрөг, уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээний суурь тарифыг 200.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 450.0 мянган төгрөгт хүргэсэн нь тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлсэн ач холбогдол бүхий ажил болсон байна.

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ЭСЭХ ТАЛААР:

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны “Системчилсэн үнэлгээ хийх тухай” 05 дугаар тогтоолоор Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудад үйл ажиллагааны тайлангаа Улсын Их Хуралд ирүүлэхдээ “Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийж ирүүлэх үүрэг чиглэл өгсний дагуу ЭМДҮЗ нь 2021 оны үйл ажиллагааны тайландаа системчилсэн үнэлгээг хийж ирүүлсэн байна.

Системчилсэн үнэлгээний зорилго нь байгууллагын үйл ажиллагааны үр өгөөж, өөрийн тавьсан зорилгодоо ямар хэмжээнд хүрсэн байдлыг тодорхойлох буюу тухайн байгууллагын дотоод үйл ажиллагааг үнэлэхэд чиглэгддэг.

Системчилсэн үнэлгээний төрлүүд болох байгууллагын чиг үүргийн үнэлгээ, байгууллагын үйл ажиллагааны журмын /процессын/ үнэлгээ, хүний нөөцийн хэрэгцээний үнэлгээ, санхүүгийн буюу захиргааны зардлын үнэлгээ гэсэн үнэлгээний төрлүүдийн алийг нь сонгон хийсэн талаар мэдээлэл байхгүй байна. Харин системчилсэн үнэлгээ хийх болсон зорилгыг “байгууллагын үйл ажиллагааны үр өгөөж, өөрийн тавьсан зорилгод ямар хэмжээнд хүрснийг тодорхойлоход чиглэнэ” гэж тодорхойлсон хэдий ч тус үнэлгээний тайланд ЭМДС-ийн 2021 оны төсөв, түүний гүйцэтгэл, ЭМДС-ийн зарцуулалттай холбоотой мэдээллийг голчлон оруулсан байна.

Байгууллагын хүний нөөцийн үнэлгээг хийхдээ хүний нөөцийн хэрэгцээ, хангамжид хийсэн дүгнэлт байхгүй, зайлшгүй шаардлагатай асуудлыг тусгаагүй, хэт ерөнхий мэдээлэл агуулсан байдлаар тайлагнасан байна. Тухайлбал, “Эрүүл мэндийн даатгалын байгууллагад нийт 222 ажилтан, албан хаагч ажиллаж байна. Үүнээс төрийн захиргааны албан хаагч 183 буюу 82,4 хувь, төрийн үйлчилгээний албан хаагч 39 буюу 17.6 хувь

байна. Удирдах албан тушаалтан 36, гүйцэтгэх албан тушаалтан 147 байна. Төрийн захиргааны албан хаагчаас ахлах түшмэл 33, дэс түшмэл 70, туслах түшмэл 1 байна. Нийт 45 улсын байцаагч ажиллаж байна” гэж тайлагнаад хүний нөөцийн мэдээллийг албан тушаалын ангилал, боловсрол, мэргэжил, насны байдал зэргээр ангилан үзүүлсэн байна. Харин тус салбарын ажилтны хүний нөөцийн хүртээмж, мэдлэг чадварын түвшин хангалттай эсэх, хөдөө, орон нутгийн ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа зэрэгт дүн шинжилгээ хийж, тулгамдаж буй асуудлаа тодорхойлоогүй орхигдуулсан байна.

Системчилсэн үнэлгээний тайлангаас харахад уг үнэлгээ нь шаардлагатай хүний нөөцийг тодорхойлох, үйл ажиллагааны зардлын үр өгөөжийг дээшлүүлэх зэрэг системчилсэн үнэлгээний үр дүнг үзүүлээгүй хэдий ч тухайн байгууллагын тодорхой чиг үүргийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний ололттой талыг илрүүлж, цаашид анхаарах асуудлын талаарх саналыг өнөөгийн нөхцөл байдалд хийх дүн шинжилгээгээр гаргаж тавьсан нь байгууллагын чиг үүргийн үнэлгээний арга зүйг ашигласныг илтгэж байна. Тухайлбал, 2021 оны үйл ажиллагааны үр дүнд гарсан 9 эерэг хандлага, өөрчлөлтийг тодорхойлж өгсөн байна. Үүнд:

- Тусламж үйлчилгээний суурь тарифыг нэмэгдүүлсэн;
- Эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөрийг хариуцах тусламж, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлсэн;
- Эрүүл мэндийн даатгалын байгууллагыг үндэсний хэмжээний бүтцийг байгуулж 21 аймаг, Багануур, Налайх дүүрэгт Эрүүл мэндийн даатгалын хэлтсийг байгуулсан;
- Эрүүл мэндийн даатгалын цахим системийг үе шаттайгаар хөгжүүлсэн зэрэг 9 эерэг үр дүнг дурдсан байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.3 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны тайланд шинжилгээ хийлээ.

ЭМДҮЗ-өөс Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороонд ирүүлсэн “ЭМДҮЗ-ийн 2021 оны үйл ажиллагааны тайлан” болон “байгууллагын үйл ажиллагаанд хийсэн системчилсэн үнэлгээний тайлан”-гийн хүрээнд Улсын Их Хурлын Тамгын газраас шинжилгээ хийж, дараах санал, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. ЭМДҮЗ нь 2021 оны үйл ажиллагааны тайлангаа Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 05 дугаар тогтоолын дагуу системчилсэн үнэлгээ хийж өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилтийн эерэг үр дүнг тодорхойлсон боловч гарч байгаа хүндрэл, бэрхшээл, тулгарч буй асуудлыг тодорхойлж, бодит байдлаар дүн шинжилгээ хийж, тэдгээрийг шийдвэрлэхэд чиглэсэн тодорхой санал гаргаагүй байна;
2. Үйл ажиллагааны тайлангаас харахад хэрэгжилт хангалттай буюу бүрэн хэрэгжсэн, үр дүнтэй арга хэмжээнүүдийг голчлон тайлагнасан бөгөөд тайлант онд хэрэгжээгүй болон хэрэгжилт хангалтгүй үлдсэн хичнээн арга хэмжээ байгаа, тэдгээрийн шалтгааны талаар тайлагнаж ирүүлээгүй байна. Хэрэгжээгүй, хэрэгжилт хангалтгүй байгаа арга хэмжээ, тогтоол шийдвэрүүдийн хэрэгжээгүй шалтгаан нөхцөлийг тодруулан тайлагнаж ирүүлэх, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд тулгарч байгаа хүндрэлтэй асуудлуудын талаар тайлагнах нь дараа оны үйл ажиллагааг оновчтой төлөвлөх, улмаар шийдвэрлэх гарцыг тодорхойлох боломжтой юм;
3. Байгууллагын үйл ажиллагаанд свот шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудлаа тодорхойлж, бий болсон ололттой, давуу талаа ашиглаж сул,

эрсдэл үүсгэхүйц асуудлыг нөхөн шийдвэрлэх талаар хувилбар дэвшүүлж, ирэх жилийн төлөвлөгөөнд тусган, биелэлтийг хангаж ажиллахад анхаарах нь зүйтэй. Мөн жилийн үйл ажиллагааны тайландаа гадны шинжээчдийн үнэлгээний багаар хөндлөнгийн үнэлгээний хэлбэрийг сонгож үнэлгээ хийлгэвэл хараат бус бие даасан, илүү бодитой үнэлгээний дүн гарч байгууллагын алдаа дутагдлыг олж харах давуу талтай болохыг зөвлөж байна.

4. Цаашид Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12-т заасны дагуу тухайн жилийн үйл ажиллагааны тайланг ирүүлэхдээ хуулиар олгосон бүрэн эрх, чиг үүргийн дагуу бүрэн гүйцэд, иж бүрэн, товч тодорхой үр дүнд чиглэсэн байдлаар тайлагнах, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлснээр гарсан эерэг болон сөрөг үр дүнг хүрсэн түвшингээр харьцуулан тайлагнаж ирүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗАР